



ДУНДГОВЬ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2023 оны 04 сарын 13 өдөр

Дугаар

А/15

Мандалговь

「Баримт актлан устгах комисс томилох тухай」

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67,5, Архив албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 21.1.6 Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2021 оны 10 дугаар сарын 06-ний өдрийн А/222 дугаар тушаалаар батлагдсан “ Байгууллагын архивын үйл ажиллагааны нийтлэг журам”-ын 2.8, 2.9, 2.10 дахь заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. Аймгийн Засаг Даргын Тамгын Газрын баримтыг актлан устгах комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Комиссын дарга: Н.Түвшинжаргал (Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)

Гишүүдэд: Б.Энхмандал (Хууль эрх зүйн хэлтсийн хууль тогтоомж, системчлэл, лавлагаа, хүний эрх, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх бодлого хариуцсан мэргэжилтэн)

Г.Цэрэндолгор (Цэргийн штабын нөхөн хангалт, тоо бүртгэлийн офицер)

Ц.Баттулга (Цэргийн штабын орон нутгийн хамгаалалт, сургалтын офицер)

Г.Мөнхбаясгалан (Санхүү төрийн сангийн бүртгэлийн мэргэжилтэн)

Ц.Баярмагнай (Нийтлэг үйлчилгэний албаны Жолооч)

Нарийн бичгийн дарга: М.Энхбат (Цахим архив, техникийн оператор хариуцсан ажилтан)

2. Аймгийн Засаг Даргын Тамгын Газрын устгах 266 хадгаламжийн нэгж баримтыг нүд үзэж устгахыг комиссын гишүүдэд үүрэг болгосугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ  
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Л.ДОРЖБАТ

40 3150023